

**ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД,  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

---

**2018 оны 03 дугаар сарын . . . өдөр**

**Дугаар**

**Улаанбаатар хот**

**Журам батлах тухай**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дэх хэсэг, Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйл, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх журам”-ыг хавсралтаар баталсугай.
2. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар/Б.Нямдаваа/-т үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн хангаж, мөрдөж ажиллахыг Мэргэжлийн боловсрол, сургалтын Үнэлгээний төв/Ц.Батдорж/, Политехник коллеж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирлуудад тус тус даалгасугай.
4. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Гэгээрлийн сайдын 1999 оны 246 дугаар тушаалаар батлагдсан “Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх журам”, Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/263 тоот тушаалаар батлагдсан “Чадамжийн үнэлгээний журам”-ыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ХӨДӨЛМӨР,НИЙГМИЙН  
ХАМГААЛЛЫН САЙД

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ  
УХААН, СПОРТЫН САЙД

С.ЧИНЗОРИГ

Ц.ЦОГЗОЛМАА

## **“СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДЛЫГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ”-ЫН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА**

Мэргэжлийн боловсрол сургалтын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх журмыг Хөдөлмөрийн болон боловсролын асуудал эрхэлсэн засгийн газрын гишүүн хамтран батлах”-аар заасны дагуу Гэгээрлийн сайдын 1999 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлж, дүгнэх үлгэрчилсэн журам”-ийг шинэчлэн боловсруулж баталгаажуулахаар төслийг танилцуулж байна.

Мэргэжлийн боловсрол сургалтын чиг хандлага орц, үйл явцыг чухалчлахаас илүүтэй үр дүн, чадамжийг чухалчилсан тогтолцооны шинэчлэл, бүтэц бүрэлдэхүүний өөрчлөлт, техник, технологийн хөгжлийг дагасан сургалтын хөтөлбөрийн агуулгын шинэчлэл зэрэг хүчин зүйлээс шалтгаалан мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг хэрхэн үнэлж, баталгаажуулах энэ үйл ажиллагаанд оролцогч талуудын чиг үүргийг тодорхой болгох асуудлыг шинэ зохицуулалтаар хангах шаардлага тулгарч байна.

Энэхүү журмыг шинэчлэн баталж мөрдсөнөөр суралцагчийн мэдлэг, үр чадвар, хандлага төлөвшлийг стандарт, чанарын үнэлгээнд нийцүүлэн сургалтын явцад болон чадамжийн нэгжийн эзэмшсэн байдлаар, мөн улирлын, төгсөлтийн явцад хэрхэн үнэлж, үнэлгээг зохион байгуулах, үнэлгээний төрөл, шалгуур аргачлалыг тодорхой болгох юм.

Багш, сургалтын албанаас сургалтын үйл явц, үр дүнд үнэлгээ хийж, сургалтын стандарт, хөтөлбөрийн хүрэх үр дүнтэй харьцуулсан дүгнэлт гарган цаашид сургалтын явцад илүү идэвхитэй зохистой арга хэлбэрийг сонгон хэрэглэх замаар сургалтын чанар үр дүнг байнга дээшлүүлэх үндсэн механизм болно гэж үзэж байна.

Гэгээрлийн сайдын 1999 оны А/246 дугаар тушаалаар батлагдсан “Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлж, дүгнэх үлгэрчилсэн журам”-д нийцүүлэн сургалтын байгууллага бүр мэргэжлийн хичээлээр суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлж, дүгнэх үзүүлэлтийг тусгасан шалгалт, шүүлгийн дүрэм боловсруулан мөрдөж ирсэн. Одоогийн Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хуулинд энэхүү журмыг батлахаар тусгайлан эрх олгосон заалт нь үлгэрчилсэн бус шууд мөрдөх журам тул үнэлгээний төрөл, арга хэлбэр, зохион байгуулалт, оролцогч талуудын эрх, үүрэгтэй холбогдох нарийвчилсан зохицуулалтыг журмын төсөлд тусгасан болно.

Журмын төслийг боловсруулахдаа Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/197 дугаар тушаалаар баталсан “Чадамжид суурилсан сургалтын хөтөлбөрийн загвар, загварыг ашиглах зөвлөмж”-д тусгагдсан үнэлгээний төлөвлөгөө, төлөвлөгөө боловсруулах аргачлал, үнэлээний удирдамж, үнэлгээний орчин, үнэлгээний хэрэгсэл, зохион байгуулалттай холбогдох асуудлаар давхцал үүсгэхгүй, гагцхүү оролцогч талуудын чиг үүргийг тодорхой болгож, хариуцлагажуулахад голлон анхаарсан болно. Журмын төсөлд сургалтын байгууллага, бүсийн арга зүйн төв, үнэлгээний төвийн төлөөлөл оролцсон 3 удаагийн хэлэлцүүлэгээр болон и-мэйлээр саналыг авч нэгтгэн тусгасан. Энэхүү журам хэрэгжүүлэхтэй холбогдон нэмэлт зардал гарахгүй тул зардлын тооцоолол хийгээгүй болно.

Төсөл  
Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Боловсрол,  
соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2018 оны  
... дугаар сарын ... ний өдрийн ..... дугаар  
хамтарсан тушаалын хавсралт

## **СУРАЛЦАГЧИЙН МЭДЛЭГ, ЧАДВАР, ДАДЛЫГ ҮНЭЛЭХ, ДҮГНЭХ ЖУРАМ**

### **НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус өмчийн политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчийн мэдлэг, ур чадвар, хандлага төлөвшил, дадлын түвшин түүний ахиц өөрчлөлтийг үнэлж, дүгнэхэд энэхүү журмыг баримтална.
- 1.2. Техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын сургалтын чанар, үр өгөөжийг дээшлүүлэх, стандарт, чанарын үнэлгээнд нийцсэн сургалтын явцын, чадамжийн нэгжийн, улирлын, төгсөлтийн үнэлгээ хийхтэй холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.3. Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэх, дүгнэх, баталгаажуулах үйл ажиллагааг Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж<sup>1</sup> -ид нийцүүлэн гаргасан холбогдох дүрэм, журмын хүрээнд хэрэгжүүлнэ.
- 1.4. Журмын үйлчлэх хүрээ:
  - Техникийн болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын байгууллагын суралцагч.
- 1.5. Бүрэн дунд боловсрол олгох сургалтын ерөнхий эрдмийн хичээлийн үнэлгээг Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2013 оны А/309 дугаар тушаалаар батлагдсан “Ерөнхий боловсролын сургуулийн суралцагчийн болон боловсролын чанарын үнэлгээний журам”-аар зохицуулна.
- 1.6. Политехник коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтийн чанарт хөндлөнгийн үнэлгээг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2016 оны А/50 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам”-аар зохицуулна.

<sup>1</sup> Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын багшийн сургалтын ажлыг багц цагаар тооцох журам, Төгсөгчдөд боловсролын баримт бичиг олгох журам,

- 1.7. Энэхүү журамд тусгагдсан дор дурьдсан нэр томъёог дараах утгаар ойлгоно:
  - 1.7.1. “үнэлгээний баг” гэж суралцагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлагыг үнэлэхээр эрх бүхий байгууллагаас албан ёсоор томилогдсон ажлын хэсэг;
  - 1.7.2. “үнэлгээний ажилтан” гэж суралцагчийн мэргэжлийн мэдлэг, ур чадвар, хандлага, төлөвшлийг тодорхойлоход чиглэсэн нотолгоо цуглуулах, нотолгоо нь сургалтын стандарт, чадамжийн нэгж, элемент, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлттэй нийцэж байгаа эсэхийг хянах, дүгнэх үүрэгтэйгээр эрх бүхий байгууллагаас томилогдсон ажилтан;
- 1.7.3. “баталгаажуулалтын ажилтан” гэж үнэлгээ нь үнэлгээний төлөвлөгөө, үнэлгээний удирдамж, хяналтын хуудас, үнэлгээний үйл явц, стандарт, журмын дагуу зохион байгуулагдсан эсэхийг хянах, үнэлгээний тохирц, найдвартай байдлыг шалгах дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх эрх бүхий ажилтан;
- 1.7.4. “үнэлгээний арга” гэж тухайн мэргэжил, чадамжийн нэгжийн элементийн агуулгаас хамааран мэдлэг, ур чадвар, хандлагыг хэрхэн, яаж үнэлэх үйл ажиллагаа;
- 1.7.5. “үнэлгээний төлөвлөгөө” гэж хэзээ, хаана, хэрхэн, яаж үнэлэхийг тухайн жилд урьдчилан төлөвлөсөн баримт бичиг;
- 1.7.6. “хөндлөнгийн үнэлгээ” гэж үнэлгээний эрх бүхий байгууллага хөндлөнгөөс үнэлэх, баталгаажуулах үйл ажиллагаа;
- 1.7.7. “хөндлөнгийн баталгаажуулалт” гэж үнэлгээ нь төлөвлөгөө, стандарт, холбогдох дүрэм, журмын дагуу зохион байгуулагдсан эсэхийг хянах, баталгаажуулах үйл явц;
- 1.7.8. “дотоодын баталгаажуулалт” гэж үнэлгээний багаас хийсэн үнэлгээ нь төлөвлөгөө, стандарт, холбогдох журмын дагуу зохион байгуулагдсан эсэхийг хянах, дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх үйл явц;

## **ХОЁР. ҮНЭЛГЭЭНИЙ ТӨРӨЛ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

- 2.1. Боловсролын үнэлгээний стандартад нийцүүлэн үнэлгээний арга зүй, төрөл, хэлбэрийг уян хатан тогтоож, тухайн сургалтын хөтөлбөрийн хүрэх үр дүнг илрүүлэхүйц, агуулгыг бүрэн хамруулсан байна.
- 2.2. Суралцагчийн мэдлэг, чадвар, дадлыг үнэлэхэд Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2017 оны А/50 дугаар тушаалаар баталсан “Мэргэжлийн боловсрол сургалтын байгууллагын төгсөгч, мэргэжлийн ур чадвар эзэмшсэн иргэний мэргэшлийн түвшинг үнэлж, баталгаажуулах, хөндлөнгийн шалгалт зохион байгуулах журам”-ын 2.1-т тусгасан зарчим, 2.5-д тусгагдсан ерөнхий шалгуурыг тус тус баримтална.
- 2.3. Суралцагчийг үнэлж, дүгнэх шалгуурыг тухайн хичээлийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх суурь, сонгох хэсгийн агуулгын хүрээнд боловсруулж, үнэлгээний төрөл, арга хэлбэрийг зөв оновчтой сонгоно.
- 2.4. Мэргэжлийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн үнэлгээг чадамжаар/чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй/, ерөнхий суурь хэсгийн хичээл, техникийн боловсрол олгох сургалтыг бүхэлд нь стандарт үнэлгээгээр үнэлнэ.
- 2.5. Суралцагчийн эзэмшсэн мэдлэг, чадвар, дадлын түвшин, түүний ахиц өөрчлөлтийг сургалтын явцын, чадамжийн нэгжийн, улирлын, төгсөлтийн үнэлгээний төрлөөр үнэлнэ.

- 2.2.1 “Явцын үнэлгээ” гэж ээлжит хичээлийн үеэр суралцагчийн эзэмшиж буй мэдлэг, ур чадвар, төлөвшлийн ахиц, өөрчлөлтийг тогтоох үйл явц;
- 2.2.2 “Чадамжийн нэгжийн үнэлгээ” гэж тухайн чадамжийн нэгжийн хүрээний мэдлэг, ур чадвар, хандлагыг цогцоор нь эзэмшсэн эсэхийг тогтоох, баталгаажуулах үйл явц;
- 2.2.3 “Улирлын үнэлгээ” гэж тухайн улиралд судалсан хичээлийн агуулгыг бүрэн эзэмшсэн эсэхийг тодорхойлох үйл явц;
- 2.2.4 “Төгсөлтийн үнэлгээ” гэж тухайн мэргэжил, мэргэшилд хамаарах хичээлийн агуулгын хүрээний цогцоор нь эзэмшсэн эсэхийг төгсөлтийн явцад тогтоох, баталгаажуулах үйл явц;
- 2.6. Техникийн боловсрол олгох сургалт нь 90-ээс доошгүй багц цагаар хэмжигдэх бөгөөд явцын үнэлгээ, улирлын үнэлгээ, төгсөлтийн үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ.
- 2.7. Мэргэжлийн боловсрол олгох сургалт нь 3500 доошгүй цагаар хэмжигдэх бөгөөд явцын үнэлгээ, чадамжийн нэгжийн үнэлгээ, төгсөлтийн үнэлгээний төрлийг хэрэгжүүлнэ.
- 2.8. Мэргэжлийн сургалтын үргэлжлэх хугацаа нь тухайн чадамжийн нэгжийг эзэмшүүлэх хугацаагаар хэмжигдэх бөгөөд явцын үнэлгээ, чадамжийн нэгжийн үнэлгээг хэрэгжүүлнэ. Энэ тохиолдолд чадамжийн нэгжийн үнэлгээ нь төгсөлтийн үнэлгээ болно.
- 2.9. Энэхүү журмын 2.5–т заасан үнэлгээний төрлийг онолын, ур чадварын хэсгээс шалтгаалан үнэлгээний дараах арга хэлбэрээс сонгон зохион байгуулна. Үүнд:
- 2.9.1. Мэдлэгийг системтэй бүрэн эзэмшсэн байдлыг хяналтын ажил, тест, илтгэл, реферат, тайлан, төсөл бичих, тооцоолох, эссэ, зохиомж найруулан бичих, аялалын маршрут зохиох, ажиглах, тайлбарлах, ярилцлага, маргаан, мэтгэлцээн хийх зэрэг аргаар онолын хэсгийг үнэлнэ.
- 2.9.2. Мэдлэгийг бүтээлчээр тодорхой нөхцөлд шилжүүлэн дадлагын ажил, сорил туршилт, үйлчилгээ, бүтээл, бүтээгдэхүүн үйлдвэрлэл, даалгавар өгөх, төслийн ажил гүйцэтгүүлэх зэрэг аргаар ур чадварын хэсгийг үнэлнэ.
- 2.10. Сургалтын албанаас дотоодын баталгаажуулалтыг улиралд нэг удаа хийнэ. Үнэлгээний төлөвлөгөөний дагуу стандарт, холбогдох журамд нийцүүлэн дотоодын үнэлгээ зохион байгуулагдсан эсэхийг хянах, дүгнэлт гаргах, санал зөвлөмж өгөх үүрэг бүхий ажлын хэсгийг томилж дотоодын баталгаажуулалтыг хэрэгжүүлнэ.
- 2.11. Явцын үнэлгээний зохион байгуулалт:**
- 2.11.1. Багш хичээлийн явцын үнэлгээг хийхдээ агуулгын аль хэсэгт суралцагч мэдлэг, ур чадварыг бүрэн эзэмшиж чадахгүй байгааг шинжлэн тогтоож, гүйцэтгэлийн хувиар тооцож, нотолгоог бүрдүүлнэ. Дүнг журналд стандарт тэмдэглэгээгээр тэмдэглэнэ.
- 2.11.2. Чадамжийн элементийг эзэмшүүлэх явцад болон төгсгөлд явцын үнэлгээг хийнэ. Элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтүүдийн дагуу гүйцэтгэлд тохирсон ажилбарын хүрээнд мэргэжлийн багш ажлын даалгаврыг боловсруулна. Даалгаврын агуулгаас хамаарч үнэлгээний арга хэлбэрийг сонгоно.
- 2.11.3. Явцын ур чадварын үнэлгээнд шаардлагатай материал, багаж, хэрэгслийг хичээл заасан багш бэлтгэж, үнэлгээний орчныг бүрдүүлнэ.

**2.12. Чадамжийн нэгжийн үнэлгээний зохион байгуулалт:**

- 2.12.1. Тухайн чадамжийн нэгжийг судалж дууссаны дараа нэгжийн үнэлгээг зохион байгуулна. Чадамжийн нэгжийн элементийн гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийн

хүрээнд гүйцэтгэлд тохирсон ажилбарын ажлын даалгавар болон онолын мэдлэг үнэлэх үнэлгээний материалыг мэргэжлийн багш боловсруулж, сургалтын менежер хянаж, баталгаажуулна.

- 2.12.2. Хөндлөнгийн үнэлээний ажилтан оролцсон үнэлгээний баг чадамжийн нэгжийн үнэлгээг хийж, холбогдох тэнхим, сургалтын менежер хяналт тавина.
- 2.12.3. Чадамжийн нэгжийн үнэлгээнд “Хараахан чадамж эзэмшээгүй” (ХЧЭ) гэж үнэлэгдсэн сурагчдад агуулгыг бие даан нөхөж судлах боломж олгож, багш нар зөвлөн туслах төлөвлөгөөт хуваарийн дагуу сурагчдад дэмжлэг үзүүлнэ.
- 2.12.4. Чадамжийн нэгжийн үнэлгээний онолын болон ур чадварын дүнг журналд гүйцэтгэлийн хувь, чадамжтой, хараахан чадамж эзэмшээгүй гэсэн үнэлгээгээр тэмдэглэж, улирлын дүн гаргах суурь нөхцлийг бүрдүүлнэ.
- 2.12.5. Чадамжийн нэгжийн үнэлгээний төлөвлөгөө, удирдамжийн дагуу үнэлгээнд шаардлагатай түүхий эд материал, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын тооцоог тухайн мэргэжлийн багш хийж, сургалтын байгууллага үнэлгээний орчныг бүрдүүлнэ.

### **2.13. Улирлын үнэлгээний зохион байгуулалт:**

- 2.13.1. Улирлын үнэлгээ нь техникийн болон мэргэжлийн боловсрол сургалтын стандарт, хөтөлбөрт нийцсэн, тухайн улиралд үзсэн хичээлийн агуулгыг бүрэн хамарсан байна.
- 2.13.2. Улирлын үнэлгээг батлагдсан төлөвлөгөөний дагуу улирлын төгсгөлд зохион байгуулна. Сургалтын албанаас сургалтын төлөвлөгөөнд тусгагдсан хичээл бүрээр улирлын шалгалтын хуваарийг гаргаж, баталгаажуулан ажлын 2-оос доошгүй долоо хоногийн өмнө багш, суралцагчдад мэдээлнэ.
- 2.13.3. Улирлын үнэлгээний багийг захирлын тушаалаар байгуулна.
- 2.13.4. Улирлын үнэлгээний онолын мэдлэг шалгах материалыг сургалтын хөтөлбөрт үндэслэн холбогдох тэнхимийн мэргэжлийн багш 4-өөс доошгүй хувилбартайгаар боловсруулна. Сургалтын алба тухайн хувилбараас сонгож шалгалтыг хуваарийн дагуу зохион байгуулна.
- 2.13.5. Үнэлгээний баг шалгалт эхлэхээс 1 хоногийн өмнө сонгосон шалгалтын материалын нууцлалыг алдагдуулахгүй хувилж, битүүмжилнэ.
- 2.13.6. Үнэлгээ явагдаж эхлэхээс 15 минутын өмнө шалгагч багш үнэлгээний танхимд сурагчдыг бүртгэж, суудал хуваарилан суулгаж, үнэлгээний дэгийг танилцуулан материалыг тараана.
- 2.13.7. Улирлын үнэлгээний материалыг мэргэжлийн багш засч, дүнг тухайн өдөрт нь мэдээлнэ.
- 2.13.8. Үнэлгээний багийн шийдвэрийн дагуу улирлын үнэлгээнд хүндэтгэх шалтгаанаар хамрагдаагүй болон хангалтгүй үнэлгээ авсан суралцагчийг 14 хоногийн дотор шалгалтын хуваарь гарган дахин үнэлгээнд хамруулна.
- 2.13.9. Суралцагчийн улирлын үнэлгээний дүнг сургалтын алба баталгаажуулан мэдээллийн нэгдсэн системд оруулна.
- 2.13.10. Улирлын үнэлгээний дүнд дүн-шинжилгээ хийх, тестийн сан бүрдүүлэх ажлыг сургалтын менежер, үнэлгээний баг хариуцан гүйцэтгэнэ.

### **2.14. Төгсөлтийн үнэлгээний зохион байгуулалт:**

- 2.14.1. Төгсөлтийн үнэлгээ нь техникийн болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын стандарт, хөтөлбөрт нийцсэн тухайн мэргэжлийн ерөнхий суурь, мэргэжлийн суурь, мэргэшүүлэх суурь, сонгон судлах хичээлийн агуулгыг бүрэн хамарсан байна.
- 2.14.2. Төгсөлтийн үнэлгээнд улирлын болон чадамжийн нэгжийн үнэлгээнд тэнцсэн, техникийн болон мэргэжлийн боловсрол, мэргэжлийн сургалтын стандарт, хөтөлбөрийн шаардлагыг хангасан суралцагч орно.
- 2.14.3. Төгсөлтийн үнэлгээний багийн бүрэлдэхүүн, удирдамжийг сургалтын байгууллага тухай бүр батлан удирдлага зохион байгуулалтаар хангана.
- 2.14.4. Үнэлгээний баг нь суралцагчдын даалгаврын гүйцэтгэлийг шалгуур үзүүлэлтийн дагуу ажиглах, нэмэлт асуулт тавьж хариулт авах, гүйцэтгэлийн үр дүнд үзүүлэлт бүрээр үнэлгээ өгч дүнг нэгтгэнэ.
- 2.14.5. Сургалтын менежер, үнэлгээний баг материалыг хүлээлцэх, задлах, хувилах, үнэлгээний дүнг нэгтгэн холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг зохион байгуулна.
- 2.14.6. Үнэлгээний баг төгсөлтийн үнэлгээний явц, давуу болон сул тал, цаашид анхаарах асуудлын талаар дүгнэлт гаргана.
- 2.14.7. Мэргэжил эзэмшихээр суралцаж байгаа тохиолдолд бүх чадамжийн нэгж /хичээлийг эзэмшиж, “Чадамжтай/Хангалттай” гэж үнэлэгдсэн тохиолдолд төгсөлтийн үнэлгээнд орох эрхтэй.
- 2.14.8. Чадамжийн нэгж эзэмшихээр суралцаж байгаа тохиолдолд чадамжийн нэгжийн үнэлгээ нь төгсөлтийн үнэлгээ байна.
- 2.14.9. Төгсөлтийн үнэлгээ нь хөндлөнгийн байж болох бөгөөд энэ тохиолдолд сургалтын байгууллага, Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвтэй хамтран зохион байгуулна. Үнэлгээнд дүнд дүн шинжилгээ хийх, тестийн сан бүрдүүлэх ажлыг Мэргэжлийн боловсрол үнэлгээний төв хариуцан гүйцэтгэнэ.
- 2.14.10. Хөндлөнгийн үнэлгээ хийгдэж байгаа үед сургалтын байгууллага суралцагчийн суралцсан хугацааны мэдээлэл бусад нотлох баримтыг Мэргэжлийн боловсрол, сургалтын үнэлгээний төвд тогтоосон хугацаанд гаргаж хүргүүлнэ.
- 2.14.11. Энэхүү журамд тусгагдаагүй зохион байгуулалтын чанартай аливаа асуудлыг шалгалтын болон үнэлгээний удирдамжаар тухай бүр зохицуулна.

### **ГУРАВ. ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР**

- 3.1.1. Мэргэжлийн болон мэргэжлийн боловсрол олгох сургалтын мэргэжлийн суурь, мэргэшүүлэх хичээлийн үнэлгээг чадамжаар/чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй/, бүрэн дунд боловсрол олгох ерөнхий суурь хэсгийн хичээл, техникийн боловсрол олгох сургалтын үнэлгээг А, В, С, D, F буюу стандарт үнэлгээгээр үнэлнэ.
- 3.1.2. Чадамжтай, хараахан чадамж эзэмшээгүй гэсэн үнэлгээг Үнэлгээний хяналтын хуудасанд заагдсан гүйцэтгэлийн хувийг хэрхэн хангаж байгааг шалгуур болгон үзнэ.
- 3.1.3. Техникийн боловсрол олгох сургалтын суралцагчдын А, В, С, D, F буюу стандарт үнэлгээг хийхдээ журмын 3.1.4-3.1.7 заалтыг харгалзан үзнэ.
- 3.1.4. Суралцагчийн мэдлэгийг тухайн мэргэжилд зайлшгүй шаардлагатай суурь мэдлэгийн үндсэн ойлголтоор, ур чадварыг онолын мэдлэгээ тодорхой нөхцөлд хэрэглэх чадвар эзэмшсэн байдлыг харгалзан явцын үнэлгээг 70 хүртэлх оноогоор үнэлнэ.
- 3.1.5. Улирлын үнэлгээг 30 хүртэлх онооны шалгалт авч дүгнэнэ.
- 3.1.6. Явцын болон улирлын үнэлгээний нийлбэр оноогоор 60-аас доош үнэлэгдсэн бол дахин үнэлгээнд хамрагдана.

- 3.1.7. Явцын болон улирлын үнэлгээний нийлбэр 100 хүртэлх оноог дараах лавлах хүснэгтэд үсгэн, тоон болон хувьчилсан оноог харгалзуулсан утгаар шилжүүлэн ойлгоно. Үүнд:
- 3.1.8. Суралцагчийн сурлагын чанарыг улирал бүрийн мөн нийт суралцсан хугацааны үнэлгээний оноо ба голч дүнгээр тодорхойлно.

### Үнэлгээний лавлах хүснэгт

Түвшин/хүрэх үр дүн, шалгуур		Оноо	Үнэлгээ	Голч дүн
Сурлагын дээд түвшин (90-100 хувь)	Тухайн хичээлийн мэдлэгийг системтэй эзэмшиж, нэгтгэн дүгнэх, задлан ялгах болон мэдлэгээ үйлдвэрлэл, дадлагын явцад бүтээлчээр хэрэглэх чадвар маш сайн хөгжсөн, бүрэн төлөвшсөн:	96-100	A	4.0
		90-95	A-	3.7
Сурлагын дунджаас дээш түвшин (80-89 хувь)	Хичээлийн үндсэн агуулгыг сайн эзэмшиж, холбогдох материалыг ашиглах, даалгавар гүйцэтгэх чадвартай, эзэмшсэн мэдлэгээ ижил болон өөр нөхцөлд шилжүүлэх хэрэглэх чадвартай, төлөвшсөн:	87-89	B+	3.4
		83-86	B	3.0
		80-82	B-	2.7
Сурлагын дундаж түвшин (70-79 хувь)	Хичээлийн агуулгыг дунд зэрэг эзэмшсэн уг хичээлээр хангалттай ойлголт авсан, харьцангуй энгийн даалгаврыг хийж гүйцэтгэх чадвартай, мэдлэгийг гүнзгийрүүлэн судлах шаардлагыг ухамсарласан:	77-79	C+	2.4
		73-76	C	2.0
		70-72	C-	1.7
Сурлагын дунджаас доош түвшин (60-69 хувь)	Хичээлийн агуулгыг дутуу эзэмшсэн, уг хичээлийн мэдлэгийг зохих түвшинд эзэмших, ашиглах чадвартай болохын тулд гүнзгийрүүлэн судлах нэмэлт даалгавар хийж гүйцэтгэх шаардлагатай:	67-69	D+	1.4
		63-66	D	1.0
		60-62	D-	0.7
Сурлагын доод, хангалтгүй түвшин (0-59 хувь)	Хичээлийн агуулгыг зохих түвшинд эзэмшиж чадаагүй, мэдлэг, ур чадвар, хувьд илт дутмаг, төлөвшөөгүй:	0-59	F	0

### ДӨРӨВ. ҮНЭЛГЭЭНД ОРОЛЦОГЧДЫН ЭРХ, ҮҮРЭГ

#### 4.1. Сургалтын байгууллагын эрх, үүрэг:

##### 4.1.1. Сургалтын байгууллагын эрх:

- 4.1.1.1. Үнэлгээний нэгдсэн төлөвлөгөө гаргаж баталгаажуулан оролцогч талуудад мэдээллийг бүрэн хүргэх;
- 4.1.1.2. Тодорхой үндэслэл, шалтгаанаар үнэлгээний төлөвлөгөөг бүхэлд нь буюу хэсэгчлэн өөрчлөлт хийж, зарлан мэдэгдэх;
- 4.1.1.3. Үнэлгээний багийг бүрдүүлж, үнэлгээний удирдамжийг батлах, зохион байгуулалтаар бүрэн хангах;
- 4.1.1.4. Үнэлгээтэй холбогдон гарсан аливаа санал, гомдлыг шийдвэрлэх;
- 4.1.1.5. Суралцагчийг тодорхой шалтгааны улмаас шалгалтанд оруулахгүй байх, шалгалтаас чөлөөлөх, шалгалтанд орох эрхийг сэргээх, дахин шалгалтыг зохион байгуулах;

##### 4.1.2. Сургалтын байгууллагын үүрэг:



- 4.1.2.1. Үнэлгээг зохион байгуулах эрх олгосон гэрчилгээтэй байх;
- 4.1.2.2. Үнэлгээний болон баталгаажуулалтын ажилтантай байх;
- 4.1.2.3. Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлага хангасан анги, танхим, дадлагын газар, тоног төхөөрөмж, бүхий үнэлгээний орчныг бүрдүүлсэн байх;
- 4.1.2.4. Явцын, чадамжийн нэгжийн, улирлын үнэлгээг сургалтын байгууллага, төгсөлтийн үнэлгээг сургалтын байгууллага, хөндлөнгийн үнэлгээний эрх бүхий байгууллагатай хамтран зохион байгуулах;
- 4.1.2.5. Үнэлгээг шууд хариуцан зохион байгуулах, явцад нь хяналт тавих, гүйцэтгэлийн үр дүнг тооцох, анализ дүгнэлт хийж түүний мөрөөр тодорхой арга хэмжээ авч ажиллах;

#### 4.2. **Суралцагчийн эрх, үүрэг**

##### 4.2.1. **Суралцагчийн эрх:**

- 4.2.1.1. Суралцагч нь сургалтын төлөвлөгөөний нийт цагийн 40 хувь ба түүнээс дээш цагт хүндэтгэх шалтгаан(өөрөө өвчлөх, ар гэрийн гачигдал тохиолдох)-ы улмаас хамрагдаагүй нь нотлогдсон тохиолдолд заавал эзэмших агуулгыг бие даан? дахин? судалж, үнэлгээнд орох;
- 4.2.1.2. Мэдлэг, чадвар, хандлагаа үнэн зөв, бодитой шударгаар үнэлүүлэх;
- 4.2.1.3. Суралцагч үнэлгээний баг болон шалгагч багшийн тавьсан үнэлгээг зөвшөөрөхгүй тохиолдолд сургалтын албанд гомдлыг бичгээр үнэлгээ зохион байгуулагдсанаас хойш 24 цагийн дотор гаргах;

##### 4.2.2. **Суралцагчийн үүрэг:**

- 4.2.2.1. Үнэлгээний төлөвлөгөөтэй урьдчилан танилцаж, мэдээллийг мэргэжлийн багш, үнэлгээний багаас 3-аас доошгүй өдрийн өмнө авч бэлтгэл хангасан байх;
- 4.2.2.2. Өөртөө болон бусдад хохирол учруулах ёс зүйгүй үйлдэл гаргахгүй, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчихгүй байх;
- 4.2.2.3. Үнэлгээний явцад зөвшөөрөгдөөгүй эд зүйлс, хэрэгсэл ашиглахгүй бусдаас болон бичиж тэмдэглэсэн зүйлээс хуулахгүй;
- 4.2.2.4. Үнэлгээнд орохын өмнө мэргэжлийн багшаас хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн зааварчилгааг авч гарын үсэг зурсан байх;

##### **Тав. Хяналт хариуцлага**

- 5.1.1. Үнэлгээний журам зөрчсөн багш, ажилтанд хөдөлмөрийн гэрээ, сургуулийн дотоод журамд заасны дагуу сахилгын шийтгэл ноогдуулна.
- 5.1.2. Суралцагчид үнэлгээний журам зөрчсөн тохиолдолд анхааруулга өгөх, шалгалтыг үргэлжлүүлэхгүй зогсоох хүртэл арга хэмжээ авна.
- 5.1.3. Албан ёсоор батлуулаагүй материалаар авсан шалгалтыг хүчингүйд тооцно.
- 5.1.4. Үнэлгээний явцад үнэлгээний багаас бусад хүн зохих ёсны зөвшөөрөлгүйгээр шалгалт авч буй ангид орох, суралцагчтай харилцах, садаа болох, дэмжлэг туслалцаа үзүүлэхийг

хориглоно.

### **ЗУРГАА. Санхүүжилт**

- 6.1. Чадамжид суурилсан сургалтын ур чадварын үнэлгээнд шаардагдах түүхий эд материал, багаж хэрэгсэл, сургалтын хэрэглэгдэхүүний зардлын тооцоог үндэслэн сургалтын байгууллага санхүүжилтыг шийдвэрлэнэ.
- 6.2. Үнэлгээний багийн гишүүдийн ажлын хөлсийг Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2013 оны 09 дүгээр сарын 27-ны өдрийн А\198\215 тоот тушаалаар батлагдсан "МБСБ-ын багшийн ажлыг багц цагаар тооцох журам"-ын 5.1 дэх заалтыг үндэслэн тухайн сургалтын байгууллага тооцож олгоно.
- 6.3. Үнэлгээнд хангалтгүй үнэлэгдсэн суралцагчид дахин нэг удаа үнэлгээнд орох эрх олгох бөгөөд хоёр дахь удаагаа дахин үнэлгээнд орох шаардлагатай бол тухайн чадамжийн нэгжид болон тухайн хичээлийн багц цагт ноогдох төлбөрийг сургалтын байгууллагад төлнө.

### ***ДОЛОО. Санал, гомдол шийдвэрлэх***

- 7.1. Суралцагчийн улирлын, чадамжийн нэгжийн голч дүнгийн талаар гаргасан маргааныг холбогдох тэнхимийн саналыг үндэслэн сургалтын алба шийдвэрлэнэ.
- 7.2. Суралцагч төгсөлтийн үнэлгээтэй холбоотой санал, гомдлыг үнэлгээ зохион байгуулсан өдөрт багтаан тухайн сургуулийн үнэлгээний багт гаргана. Төгсөлтийн үнэлгээний талаар иргэд, багш, суралцагчийн гаргасан гомдол, мэдээлэл, санал, хүсэлтийг үнэлгээний баг Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний төвд хүргүүлэх ба үнэлгээний төв ажлын 5 хоногт багтаан арга хэмжээ авч шийдвэрлэнэ.
- 7.3. Санал, гомдлын хариуг заасан хугацаанд багтаан мэдэгдэж, шийдвэрлэх үйл явц нь нээлттэй, ил тод, шударга байна.

### **НАЙМ. Бусад**

- 8.1. Энэхүү журамд тусгагдаагүй зохион байгуулалтын чанартай аливаа асуудлыг сургалтын байгууллага тухай бүр үнэлгээний удирдамжид тусган зохицуулна.
- 8.2. Мэргэжлийн боловсрол сургалтын үнэлгээний төв нь салбарын сургалтын чанарын үнэлгээнд дүн шинжилгээ хийж, сургалтын чанар, үр дүнг дээшлүүлэх арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.
- 8.3. Иргэн, хуулийн этгээд төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр суралцагчийн мэдлэг, чадварыг үнэлэх хөндлөнгийн шалгалт зохион байгуулахыг хориглоно.